



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/633

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Узбекистан улсын нийслэл Ташкент хотноо зохион байгуулагдах самбо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Ховд аймгаас оролцох тамирчин О.Саруул, Г.Анужин, дасгалгалжуулагч багш С.Ганхуягийн замын зардалд 4 000 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 4 000 000 төгрөг /Дөрвөн сая/ -ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5.17-д тусгагдсан "Спортын аваргууд" дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар  
сарын 03- ны өдрийн А/633 дугаар захирамжийн  
хавсралт



САМБО БӨХИЙН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД  
ОРОЛЦОХ ТАМИРЧИД, БАГШ НАРЫН ЗАМЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Овог нэр	Албан тушаал	Замын зардал /төг/
1	О.Саруул	Тамирчин	1 500 000
2	Г.Анужин	Тамирчин	1 500 000
3	С.Ганхуяг	Дасгалжуулагч	1 000 000
	Нийт		4 000 000

-оОо-